



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/447

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейн 2009 оны 64/200 дугаар шийдвэрийн дагуу жил бүрийн 10 дугаар сарын 13-ны өдөр "Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэхийг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Одонбаярт даалгасугай.

2. "Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөр"-ийг зохион байгуулахад шаардагдах зардал 1,700,000 (нэг сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101015